БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ИНДРА

1118265139 9115064

# ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 16 ДУГААР ХОРОО, НИСЭХИЙН АВТО ЗАМААС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЖИЛЧДЫН ОРОН СУУЦ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| | |
|---|---|
| **1. Ерөнхий зүйл** | Обьектын нэр: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо, Нисэхийн авто замаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилчдын орон сууц хүртэлх авто зам<br><br>Зураг төслийн иж бүрдэл:<br>• Авто замын ажлын зураг<br>• Тайлбар бичиг<br>• Техникийн шаардлага<br>• Геологийн тайлан<br>• Геодезийн тайлан<br>• Инженерийн шугам сүлжээний зураг<br>• Төсөв /Авто зам, Инженерийн шугам сүлжээ/<br>• Магадлалын дүгнэлт<br>Гудамж замын ангилал: Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам |
| **2. Барилгын талбайн үзүүлэлт** | Одоо байгаа авто зам нь шороон зам бөгөөд шинээр хатуу хучилттай авто зам барина. |
| **3. Ажлын цар хүрээ** | 1) Зураг төслийг боловсруулахдаа авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар, авто замын зураг төсөл боловсруулах даалгаврыг үндэслэх<br>2) Шинээр баригдах авто замын хучилтын хийцийг зураг төсөл боловсруулах шатанд тооцоогоор үндэслэх . |

| | |
|---|---|
| | 3) Инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах |
| **4. Ажлын хил хязгаар** | Төслийн зам нь Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо, Нисэхийн авто замаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилчдын орон сууц хүртэл үргэлжилнэ. |
| **5. Барилгын ажлын зохион байгуулалт** | 1) Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ г.м/ -ыг бүрэн хангаж ажиллана.<br>2) Гүйцэтгэгч байгууллага Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын даргын 2016 оны А/42 тоот тушаалаар батлагдсан <u>“Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага” ыг засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх хугацаанд чанд мөрдөн ажиллана.</u> Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас холбогдох БНбД-үүд, техник технологийн стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.<br>3) Тухайн замын гэрэлтүүлгийн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмийн хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ. |

| | |
|---|---|
| | 4) Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Авто замын гэрэлтүүлгийн ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. |
| **6. Бусад** | Шинээр баригдах авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө. |

**Хянасан:**

НАЗХГ-ын орлогч даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч ................ /Д.Төрбилэг/

НАЗХГ-ын БЗХ-ийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч ................ /О.Энхбаатар/

**Боловсруулсан:**

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн
Усны барилга байгууламжийн мэргэжилтэн ................ /Б.Ертис/

2020 оны..02..сарын..28...өдөр